



МҮХАЙТ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
2024 ОНЫ 4 САРЫН 1-НИЙ ӨДРИЙН
A/39 ТООТ ТУШААЛЫН ХАВСРАЛТ-2

МОНГОЛ УЛСААС ГАРАЛ ҮҮСЭЛТЭЙ ЭКСПОРТЫН БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ, ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг. Экспортын барааны гарал үүслийг тодорхойлох

1.1. МҮХАЙТ нь Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд гарал үүслийн гэрчилгээ олгох журмын дагуу гэрчилгээ олгоходоо барааны гарал үүслийг тодорхойлох зорилгоор журамд заасан үндэслэл, холбогдох нотлох баримт болон доорх аргачлалыг ашиглан тодорхойлно.

1.1.1. Үлэмж хэмжээний боловсруулалт орсон барааны гарал үүслийг тодорхойлохдоо НӨ-ийн хувийг тооцоолох "хасах арга" буюу дараах томьёогоор тооцно:

"FOB" үнэ - Гарал үүслийн бус материалын үнэ

$$\text{НӨ хувь} = \frac{\text{"FOB" үнэ}}{\text{"FOB" үнэ}} \times 100\%$$

1.2. Дараах ажилбарууд нь тухайн барааны гарал үүслийг өөрчлөгдсөнд тооцох, энэхүү журмын дагуу тодорхойлоход нөлөөлөх үндэслэл болохгүй. Үүнд:

1.2.1. тээвэрлэлт болон хадгалалтын явцад барааг хамгаалахын тулд тохиромжтой нөхцөлөөр хангах арга хэмжээ /агааржуулалт, хатаах, хөргөх, давслах гэх мэт/;

1.2.2. эсгэх, будах, угаах, ангилах, тоосноос цэвэрлэх гэх мэт энгийн хялбар үйлдлүүд;

1.2.3. савлалт, боодлыг өөрчлөх буюу савлагаа хийх хялбар хэлбэрүүд,

1.2.4. барааны шошго, тэмдэг зэрэг бусад ялгavarлах тэмдгүүдийг наах, тогтоох;

1.2.5. эцсийн бүтээгдэхүүн болгохоор эд анги, хэсгүүдийг угсрах, холих энгийн хялбар үйлдлүүд;

1.2.6. уг журмын 2.3.1-д дурдсан үйлдлүүдийн хослол буюу нийлбэр үйлдлүүд;

1.2.7. малын нядалгаа.

1.3. Гадаадын захиалагчийн материал нь гаалийн нутаг дэвсгэрт орж ирэх болон бэлэн бүтээгдэхүүн болон буцаж гаражад шаардлагатай тохиолдолд МҮХАЙТ-ЫН төлөөлөгч нь эрх бүхий этгээдийн хүсэлтээр гаалийн нутаг дэвсгэрт хамтран ажиллаж болно.

1.4. МҮХАЙТ нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцтай газар дээр нь танилцан гарал үүслийг тодорхойлох ажиллаг явуулж болно.

Хоёр. Экспортын барааны гарал үүслийн гэрчилгээнд
тавигдах шаардлага

- 2.1. Монгол улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гарал үүслийн гэрчилгээний эх хувийг 210 x 297 мм хэмжээтэй тусгай маягт бөглөн англи, монгол, орос хэл дээр үйлдэнэ.
- 2.2. Гэрчилгээний эх хувийг үрэгдүүлсэн тохиолдолд түүний баталгаатай хувийг үйлдэж "DUPLICATE" бичилтийг хийнэ.
- 2.3. Гэрчилгээний эх хувийг солих тохиолдолд түүний баталгаатай хувийг үйлдэж "ISSUED IN SUBSTITUTION" бичилтийг хийнэ.
- 2.4. Онцгой тохиолдолд барааны гарал үүслийн гэрчилгээг тухайн барааг экспортлооос өмнө буюу экспортлох явцад олгогдоогүй бол түүний баталгаатай хувийг үйлдэж "ISSUED RETROACTIVELY" бичилтийг хийнэ.
- 2.5. Гэрчилгээ бүрийг дугаарлана. Дугаарыг гэрчилгээний баруун дээд талд доорх жишгээр тавина. Үүнд:
 - эхний хоёр үсэг нь MN буюу Монгол гэсний товчлол олон улсын (country code Alpha-2) кодын ангиллын дагуу;
 - дараагийн хоёр үсэг нь импортлогч орны товчилсон нэр, улсын нэрийг олон улсын (country code Alpha-2) кодын жишгээр товчилно/;
 - дараагийн нэг оронтой тоо нь тухайн оны сүүлчийн тоо /жишээ нь 2024 он гэвэл 4 гэж бичнэ/;
 - дараагийн тоо нь гэрчилгээний дугаар байна. Тухайн дугаар тухайн жилдээ нэг удаа олгогдоно.
- 2.6. Барааны дамжин өнгөрөх орон болон боомтыг гарал үүслийн гэрчилгээнд заавал заана.
- 2.7. Үзэсгэлэн болох газрын хаяг, үргэлжлэх хугацааг гарал үүслийн гэрчилгээнд дурдаж болно.
- 2.8. Монгол улсын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээнд MYXAYT-ын гүйцэтгэх захирал, түүний эзгүйд дэд захирал гарын үсэг зурж Танхимын тусгай тэмдгээр баталгаажуулна.

-оOo-